



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 85

Мандалговь

┌ **Үндсэн хөрөнгө балансаас балансад** ┐  
**шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 78,190,000 /далан найман сая нэг зуун ерэн мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 48,220,556 /дөчин найман сая хоёр зуун хорин мянга таван зуун тавин зургаа/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурдсан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), “Дундговь-Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга (Д.Ганбаатар), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хошууч (Н.Есөн-Эрдэнэ) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:


2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 8 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны Дугаар сарын  
29-ний өдрийн Тогтоолын хавсралт

**Аймгийн Засаг даргын тамгын газрын балансаас балансад  
шилжүүлэх тээврийн хэрэгслийн мэдээлэл**

Д/Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Хүлээн авах байгууллага	
			Сери	дугаар							
1	Суудал	Тоёота ланд круйзер-100	ДУА	00-05	2006	2017.11.02	181,129	49,500,000	22,000,000	Ду. ШШГГазар	
2	Суудал	УАЗ-Пургон	ДУА	00-48	2011	2019.06.10	125,393	14,345,000	3,984,722	Эрдэнэдалай сумын засаг даргын тамгын газарт	
3	Суудал	УАЗ-Пургон	ДУА	00-49	2011	2019.06.10	97,790	14,345,000	3,984,722	Ус суваг ОНӨГ	
<b>Нийт дүн</b>											
								<b>78,190,000 /далан</b>	<b>29,969,444</b>		
								найман сая нэг зуун ерэн мянга/төгрөг	/хорин есөн сая есөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун дөчин төгрөг		